



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/611

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсэг, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан газар эзэмших эрхийн гэрчилгээг хавсралтад дурдсанаар шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших гэрээг жил бүр дүгнүүлэн, газрын төлбөрийг хугацаанд нь төлж, газар эзэмших гэрээний дагуу эзэмшихийг газар эзэмшигч иргэн аж ахуй нэгж байгууллагад даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2004 оны 07 сарын 09 өдрийн 129 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ



2025 оны 10 дүгээр сарын 07 -ны
А/611 дугаар захирамжийн хавсралт

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх нэрсийн жагсаалт

Д/д	Шилжүүлсэн ААНБ, иргэн, эцэг/эх/-ийн нэр	Газрын зориулалт	Газрын хэмжээ /м2/	Эзэмшил газрын байршил	Шилжүүлэн авсан иргэн ААНБ-ын нэр	Хугацаа	Шилжүүлэх үндэслэл
1	Банзрагч Ёндонцэвэг /СЭ54011575/	Худалдаа, нийтийн үйлчилгээний, төв, цогцолбор	450	2-р баг, Булаг, Тэмүүжин гудамж Н- 10 тоот	Мүүн валлей ХХК /7206649/	39	Эрх шилжүүлэх гэрээ